



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас Ц.Баярхүү, С.Мандахбат нарыг тус тус чөлөөлсүгэй.

2. Сангийн яамны Санхүү, худалдан авах ажиллагааны бодлогын газрын Санхүүгийн бодлогын хэлтсийн дарга Б.Батбаяр, Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга Ц.Цолмон нарыг Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

3. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг Б.Батбаяр, Ц.Цолмон нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН

0013-5